<b>Голлох бүтээгдэхүүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>▪ аж үйлдвэрийн бүтээгдэхүүн : катодын зэс, зэс, молибден, хивс</li> <li>▪ уламжлалт аж үйлдвэр : махан бүтээгдэхүүн, кашемир хувцас</li> <li>▪ газар тариалан : төмс, буудай</li> </ul>

Агаарын чанар: Хүн амын нягтрал нь үйлдвэрийн бүсээс 7-10 км алслагдсан зайд байрладаг. Орхон аймгийн агаарын бохирдолд гэр хорооллын энгийн галлагаатай зуух, дулааны станцууд, нам даралтын зуухтай аж ахуйн нэгжүүд, автомашины дотоод шаталтын хөдөлгүүрийн утаа голлох нөлөө үзүүлж байна. (Орхон аймгийн БОТБ судалгаа, 2015)

Геологийн тогтоц: Эрдэнэт хот нь Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужид хамаарагдах Орхон голын хойт талын бэсрэг уулсын дүүрэгт оршино. Хот байрлаж байгаа уулс хоорондын хөндийн өргөн дунджаар 1-2км. Энэ нутаг дэвсгэрийн геологийн тогтоц нь уул нуруу нь Палеозой, Протерозойн үеийн хүчтэй хувирч өөрчлөгдсөн терригений болон бялхмал чулуулгаас тогтоно.



Гадаргын ус: Үндсэн тэжээлийн хангалтыг агаарын хур тунадас зонхилон гүйцэтгэдэг бөгөөд хязгаарлагдмал байдлаар газрын доорх ус хам хэлбэрээр нэмэлт тэжээлийг өгнө. Хангалын голын ус цуглуулах талбай 268км<sup>2</sup>, голын нийт урт 55,9км, урсгалын хурд 0,4-1м/сек, гүн 0,3-0,8м болно. Эрдэнэт гол ус цуглуулах талбай 99км<sup>2</sup>, голын урт 7,5км, усны урсгалын хурд 0,2-0,5м/сек, гүн 0,2-0,5м байна.

Газрын доорх усны нөөц, чанар, горим: Орхон аймаг нь Сэлэнгэ мөрөн, Орхон гол гэсэн Монгол орны хоёр томоохон гол мөрний ай савд багтах нутаг дэвсгэрт оршдог боловч гадаргын болон гүний усны нөөц харьцангуй харьцангуй багатай юм.

Хөрсөн бүрхэвч: “Эрдмин” үйлдвэрийн эдэлбэр газарт ойн ширэгт бараан, хар шороон, хар хүрэн хэв шинжийн хөрс зонхилон тархдаг бөгөөд хотгор гүдгэрийн нөхцөл, хөрс үүсгэсэн чулуулгийн төрөл, тэдгээрийн илрэх гүн, хур тунадасны усны хуваарилалтын гадагуугын нөхцөл, ургамлын бүлгэмдэл зэрэг хөрс үүсвэрийн хүчин зүйлсээс хамаарч тэдгээрийн сайр чулуурхаг, ердийн, нугархаг зэрэг төрлүүдээр илэрдэг.

Ургамлын нөмрөг: ургамалжилт газарзүйн мужлалаар Орхон аймгийн нутаг дэвсгэр нь Евро-Азийн шилмүүст ой, нуга, хээрийн Их мужийн Монголын мужийн Хангайн их хошууны Дорнод хангайн бэсрэг ба нам уулсын хошууны Бүрэнгийн нурууны тойрогт багтах бөгөөд Ургамалжилт нь чийглэг хэв шинжэд хамаарна. Орхон аймгийн нутаг дэвсгэрт 46 овгийн 154 төрлийн 235 зүйлийн дээд цоргот ургамал бүртгэгдсэн байдаг. Эдгээр зүйлүүдийн дотор мод 7 зүйл, сөөг -12, сөөгөнцөр-2, заримдаг сөөг-5, олон наст өвс-194, нэг ба хоёр наст ургамал-26 зүйл, хүнсний (жимс болон цайны ургамал) 10 зүйл тохиолдоно.

Амьтаны аймаг: Амьтны аймгийн хувьд тус нутаг нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн хуваарилалтаар уулархаг Азийн дэд муж, Монгол төвдийн муж, хээрийн дэд мужийн Хангайн тойрогт хамаарна. Эрдэнэт хот байгуулагдахаас өмнө энд 2 зүйлийн загас, 2 зүйлийн хоёр нутагтан, 3 зүйлийн мөлхөгчид, ойролцоогоор 100 орчим зүйлийн шувуу, 36 зүйлийн хөхтөн бүртгэгдсэн байжээ.

Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын өв: Орхон аймгийн хувьд улсын тусгай хамгаалалттай нутаг газар нутаг байргүй бөгөөд аймгийн хэмжээнд орон нутгийн тусгай хамгаалалтад 3544,2 га бүхий Баян-Өндөр уулын орчмын газрыг байгалийн унаган төрхийг хамгаалах нөхөн сэргээх зорилгоор хамгаалалтад авсан байдаг. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолоор шинэчлэн батлагдсан уг жагсаалтад Жаргалант сумын Чингэлийн голын ай сав дагуух эртний булш хиргэсүүд хэмээгээд 175 дурсгалыг улсын хамгаалалтад, 275 дурсгалыг аймгийн хамгаалалтад авахаар оруулсан байв. Үүнийг Монгол улсын засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор Жаргалант сумын нутаг дэвсгэрт байх Айрагын гозгорын оршуулгын газар хэмээн оруулсан байдаг.



**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Нөлөөллийн хамрах хүрээг бүс нутаг, аймаг, сум, төслийн талбай гэсэн үндсэн 4 түвшинд тодорхойлов.

*Хүснэгт 41. Төслийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийн хамрах хүрээ*

№	Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Хамрах хүрээ				Болзошгүй нөлөөлөл
		Бүс нутаг	Аймаг	Сум	Үйлдвэрийн талбай	
1.	Уур амьсгалын өөрчлөлт	0	0	0	0	Агаарын температур, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх
2.	Агаарын чанарын өөрчлөлт	0	х	х	х	Агаарын бохирдол нэмэгдүүлж болзошгүй
3.	Гадаргын болон газрын доорх усны нөөц, горим, чанар	0	0	х	х	Усны нөөц хомсдох, чанар өөрчлөгдөж бохирдох зэрэг
4.	Хөрсөн бүрхэвч	0	х	х	х	Хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол үүсэх
5.	Ургамлан нөмрөг, ховор, нэн ховор төрөл зүйл өртөх	0	0	0	х	Ургамлын бүтэц өөрчлөгдөж болзошгүй
6.	Ховор, нэн ховор амьтан	0	0	0	х	Амьтдын амьдрах орчинд хязгаарлах
7.	Тусгай хамгаалалттай газар нутаг	0	0	0	0	-
8.	Чухал ач холбогдол бүхий экосистем	0	0	0	х	-
9.	Аж үйлдвэр, зам тээвэр	0	х	х	х	Үйлдвэржилт, зам тээвэр хөгжинө.
10.	Орон нутгийн усны хангамж	0	х	х	х	Усны хангамж доголдож
11.	Хаягдал усны менежмент	0	0	0	0	Хаягдал ус алдагдах
12.	Хатуу хог хаягдлын менежмент	0	х	х	х	Үйлдвэрийн хог хаягдлын төрөл, хэмжээ нэмэгдэж болзошгүй.
13.	Эрчим хүчний хэрэглээ, хангамж	х	х	х	х	Хэрэглээ нэмэгдэх
14.	Нийгэм-эдийн засгийн байдал	+	+	+	+	Ажлын байр, орлого нэмэгдэнэ.
15.	Археологи, палеонтологи	0	0	0	0	-
16.	Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдал	0	0	0	х	Ажиллагсдын эрүүл мэнд сөргөөр нөлөөлөх

*Жич: “Х”-сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай, “О”-нөлөө үзүүлэхгүй, “+”-эерэг нөлөө үзүүлэх тэмдгээр харуулав.*

Хүснэгтээс харахад “Эрдмин” үйлдвэр нь том талбайг хамарсан уурхай, үйлдвэрлэл бүтээн байгуулалтын төсөл биш учраас бүс нутаг, аймгийн түвшинд дам байдлаар агаарын чанар, эрчим хүч, нийгэм эдийн засагт нөлөөлж болзошгүй. Харин сум орон нутаг, үйлдвэрийн талбайн хүрээнд шууд болон дам байдлаар агаарын чанар, орон нутгийн ус хангамж, эрчим





хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент, нийгэм-эдийн засгийн байдал, нийгмийн эрүүл мэнд аюулгүй байдал зэрэгт нөлөөлж болзошгүй байна.

Болзошгүй нөлөөлөл гэдгийг ямар нэгэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, эсвэл нөлөөллийг бууруулах оролдлого хийгээгүй тохиолдолд ирээдүйд үүсэж болох нөхцөл байдал гэж ойлгож болно.


Болзошгүй нөлөөлөл үзүүлж буй үйл ажиллагаа тус бүрийг мөөрөөр хэлбэл төслийн байгаль орчны асуудал тус бүрийг үзүүлж буй нөлөөллийн хэмжээ, тархалтаар нь тодорхойлохын тулд харгалзах байгаль орчны элементтэй нь уялдуулан нарийвчлан судлах шаардлагатай тул доорх хүснэгтээр мөн үйлдвэрийн нөлөөллийг тоймлон харуулав.

Хүснэгт 42. Байгаль орчны нөлөөллийг тоймлох анхан шатны хүснэгт

№	Байгаль орчны элементүүд Үйл ажиллагаа	Байгаль орчны физик шинж чанар				Биологийн буюу экологийн нөөц			Хүний хэрэгцээний үнэ цэнэ					Амьдралын чанар	
		Агаарын чанар	Гадаргын усны төлөв байдал	Гүний усны төлөв байдал	Гадаргын болон гүний усны чанар	Усны ургамал, амьтан	Эх газрын ургамал, амьтан	Амьтан ургамлын төрөл зүйл	Хөдөө аж ахуй, мал аж ахуй	Газар ашиглалтын бусад төрлүүд	Усны хангамж, хүртээмж	Бохир усны менежмент	Хатуу хог хаягдлын менежмент	Нийгэм, эдийн засгийн байдал	Аюулгүй байдал, эрүүл мэнд
1.	Уусгалтын үйл явц	x	x	x	x	x	x	o	o	x	x	x	o	o	x
2.	Шимт уусмалын цөөрмүүдийн ашиглалт	x	o	x	x	o	x	o	o	x	x	x	o	o	x
3.	Уусган хандлалтын явц	x	x	x	x	o	x	o	o	x	x	x	x	o	x
4.	Электролизийн цехийн үйл ажиллагаа	x	o	o	o	o	x	o	o	x	x	x	x	o	x
5.	Шатах тослох материалын хадгалалт, ашиглалт	x	x	x	x	x	x	o	x	x	o	x	x	o	x
6.	Химийн бодисын тээвэрлэлт	x	x	x	x	x	x	o	x	x	o	x	x	o	x
7.	Химийн бодисын хадгалалт, ашиглалт	x	x	x	x	x	x	o	x	x	o	x	x	x	x
8.	Цахилгаан, шугам сүлжээний ашиглалт	x	o	o	o	o	o	o	x	x	o	o	x	x	x
9.	Усан хангамжийн шугам сүлжээний үйл ажиллагаа	o	x	x	x	o	x	x	x	x	x	x	o	x	x
10.	Газрын доорх усны ашиглалт	o	x	x	x	o	x	o	o	o	x	o	o	x	x
11.	Хог хаягдал	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
12.	Ажлын байр	o	o	o	o	o	o	o	o	o	o	o	o	+	o

Дээрх хүснэгтэд “o” “+”, эсвэл “x” тэмдгээр тэмдэглэгдсэн нүднүүд нь төслийн үйл

ажиллагаа, байгаль орчны хоорондын хамаарлыг харуулж байна. Хүснэгтээс төслийн төлөвлөж байгаа нэг ажил нь хэд хэдэн байгаль орчны элементэд нөлөөлж байна гэдгийг харж болно.



Зураг 75. Үйлдвэрийн газар ашиглалт, барилга байгууламж объектуудын байршил

### Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Төслийн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулахын тулд нөлөөллийн хэмжээг тодорхойлов. Нөлөөллийн хэмжээ үлэмж их байвал цааш нарийн судалгаа хийх бөгөөд нөлөөллийн хэмжээ бага тохиолдолд цааш судлах шаардлагагүй гэж үзэв.

Нөлөөллийн хэмжээг дараах 3 хүчин зүйлээр тодорхойлсон. Үүнд: Нөлөөллийн хэмжээ, хугацаа, нөлөөлөлд өртөх газар нутаг, нөлөөлөл тохиолдох, давтагдах магадлал. Нөлөөлөл тус бүрд дээр дурдсан хүчин зүйл болгоноор 1, 2, 3 гэсэн үнэлгээ өгөх бөгөөд энэ нь тухайн нөлөөллийн хэмжээ, тархалт, давтамжийг харуулна.

Хүснэгт 43. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ тархалтын түвшин үзүүлэлт

Хэмжээ тархалт [M] 1, 2 ба 3	Нөлөөллийн хэмжээг (бага, дунд, их) тодорхойлно. Мөн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хугацааг тодорхойлно.
Хамрах хүрээ [S] 1, 2 ба 3	Төслийн үйл ажиллагааны нөлөөлөх газарзүйн байрлал, сум орон нутаг, болон үйлдвэрийн талбайг хамарна.



Давтамж / магадлал □□1 , 2 ба 3	Дахин давтагдах магадлал ба дахин давтагдах тоо (бага магадлалтай, өндөр магадлалтай, тохиолдол нь тодорхой )
------------------------------------	---

**Эх сурвалж:** Монгол улсын байгаль орчны стратеги үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны аудитын өнөөгийн байдал, цаашид боловсронгуй болгох үнэлгээний ажлын тайлан.

Эрдмин-Катодын зэс боловсруулах үйлдвэрийн болзошгүй нөлөөллийг хэмжихийн тулд хэмжээ-тархалт, хамрах хүрээ, давтамж гурвыг үржүүлж тооцож дараах хүснэгтээр харуулав.

**Хүснэгт 44. Болзошгүй нөлөөлөл: Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ**

№	Байгаль орчны асуудал	Болзошгүй нөлөөлөл: Хэмжээ, тархалтаар ерөнхийд нь үнэлсэн үнэлгээ: Бага, Дунд, Өндөр	Нөлөөллийн эрчим	
			MxSxF	Нийт үнэлгээ, эрчим
<b>Цаг уур, уур амьсгал</b>				
1.	Химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх, полимержих зэргээр бүтээгдэхүүний шинж чанар өөрчлөгдөх, өндөр температурт хэт халснаас тэсэрч, дэлбэрэх, галын аюул гарах, бүтээгдэхүүний чанар өөрчлөгдөх, асгарч алдагдах	Бага. Химийн бодисын агуулахын агааржуулалтын системийн ажиллагаа, агааржуулалтын хоолойн бүрэн бүтэн байдал, химийн бодисын савны болон асгарсан бодис тарахаас сэргийлсэн тосгуур, суурины зузаан, идэгдэлт, химийн бодис тавьсан тавиур болон холбоосны механикийн бүрэн бүтэн байдал, тавиур дээр хадгалж буй бодисын дээд хэмжээг байнгын хяналт тавихаас гадна шатамхай, онцгой хортой бодисын сав баглаа боодлыг өдөрт 1 удаа, бусад бодисыг долоо хоногт 1 удаа шалгаж хяналтыг тогтмол хугацааны давтамжтайгаар хийж, тэмдэглэл хөтөлж байх	1x1x3	2-Бага
2.	Шингэн төлөвтэй бодисууд дулааны нөлөөгөөр тэлэх, улмаар хальж асгарах	Бага. Химийн бодисын агуулахын ажлын байр нь галд тэсвэршилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах	1x1x3	2-Бага
3.	Хадгалах температурын өөрчлөлт, хэт их халалтаас шалтгаалан найрлага шинж чанарт өөрчлөлт орох	Бага. Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх	1x1x2	2-Бага
<b>Агаарын чанар</b>				
4.	Балансын бус хүдрийн овоолгын талбай, дотоод тээврийн зам, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Дунд. Үйлдвэрээс овоолгууд хүртэл сайжруулсан шороон замтай ба хөрс шороо тээвэрлэлт хийгддэггүй. Харин үйлдвэрийн талбайн урд талын бэлд “Эрдмин-V” овоолгын сүүрийг бэлтгэн ашиглаж байгаа ба цаашид ашиглах тохиолдолд үүнтэй холбоотой тоосжилт үүсэж болзошгүй.	2x1x2	4-Бага
5.	Хүдрийн далангууд, тэдгээрийн шүлтгүйжүүлэлт хийх явцад хуурайшилт ихэссэн үед тоосжилт нэмэгдэж агаарын чанарыг бохирдуулах	Бага. Төслийн талбай орчмын 2 цэгт хийсэн мониторингийн хэмжилт үр дүнг харахад тоосжилтын хэмжээ стандартаас хэтрээгүй байсан. Харин балансын бус хүдрийн овоолгыг шилжүүлэн овоолох болон тээвэрлэлт хийх явцад агаар дахь нарийн ширхэгт тоосонцрын хэмжээ ихсэх гол эх үүсвэр болох магадлалтай.	2x3x3	18-Дунд
6.	Уусмалын хандлалт, электролизийн	Бага. Төслийн талбай Эрдэнэтийн УБҮ-ийн районд	2x3x1	2-Бага





13.	Зэс ялгах технологи, уусмалын хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас хүхрийн хүчил хөрсөн бүрхэвчид алдагдах нөлөөлөх	Хөрсний химийн элементийн жил жилийн өөрчлөлтөд дулааны улиралд олон жилийн дунджаас их орсон хур тунадасны хэмжээтэй үялдаж агуулга нь буурсан зүй тогтол илэрч байгаагаас биш зэс ялгадаг технологид хэрэглэдэг хүхрийн хүчлийн уусмалын нөлөө одоогоор хөрсний шинж чанарт шууд нөлөөлсөн гэж үзэх үндэслэлгүй байна.	1x1x2	2-Бага
14.	Төслийн үйл ажиллагаанаас хөрс хүнд металаар бохирдох	Дунд. Төслийн талбай орчмын хөрсөн бүрхэвч нь зэргэлдээх зэс молебдений орд газрын байгалийн аномалаас (гажиг) шалтгаалж Cu, Mo гэсэн металлууд ерөнхийдөө өндөр агууламжтай байна. Үйлдвэрийн бодис урвалж ба материал хэрэгслийн агуулахууд орчмын гаднах талбайн ER-4 цэгт Cu, Mo, Pb гэсэн элементүүд стандартын аюултай агууламжаас хэтэрсэн, Zn, As гэсэн элементүүд хортой агууламжаас хэтэрсэн буюу бохирдолтой байна.	2x1x2	4-Бага
15.	Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдол, химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх	Бага. Химийн бодисын агуулахын барилга байгууламж нь шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийсэн боловч нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч байх.	1x1x2	2-Бага
16.	Химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Бага. Тээвэрлэлт, хадгалалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулах, химийн бодисыг хөрсөнд алдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх	1x1x2	3-Бага
17.	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Бага. Химийн бодисын агуулахын ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон түүз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх	1x1x2	2-Бага
<b>Гадаргын ус</b>				
18.	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал усны химийн найрлагаас гадаргын ус бохирдох.	Бага. Ажиллагсдын үйлдвэрийн байр нь Эрдэнэт хотын үйлдвэрийн бүс ахуйн бохир ус зайлуулах төвлөрсөн системтэй холбогдсон байна. Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн нэгдсэн бохир ус зайлуулах системд холбогдсон тул ахуйн болон үйлдвэрлэлийн технологийн эргэлтээс бохир ус хальж асгарах орчныг бохирдуулах боломжгүй.	1x1x2	2-Бага
19.	Уусгалт, уусган хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас хүхрийн хүчлийн сулруулсан уусмал алдагдах гадаргын усанд нөлөөлөх	Бага. Уусмалын цөөрмүүдийн өмнө ба хойно бетонон далан хаалтууд хийж далангуудаас нэвчих шимт уусмалыг гадагш алдахаас сэргийлэх арга хэмжээ авсан ба алдагдсан тохиолдолд шууд гадаргын ус, гол горхид нийлэх боломжгүй байна.	1x1x2	2-Бага
20.	Шатах тослох, материал асгарах, химийн урвалж бодис асгарах зэргээс хур тунадас үерийн усаар дамжин гадаргын усанд орж бохирдол үүсгэж болзошгүй	Бага. Аливаа тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл үүсэж болзошгүй.	1x1x2	2-Бага
<b>Газрын доорх ус</b>				
21.	Хэрэглээний усыг авч ашигласнаас үүдэн газрын доорх усны нөөц	Бага. Эрдэнэт УБҮ-ийн ус хангамжийн шугамаас 159 мм-ийн хоолойгоор салаалан авч усны хэрэглээг хангадаг учир	2x2x1	4-Бага



	хомсдох	бага нөлөөтэй буюу 1.8 л/сек усны хэрэглээтэй байна.		
22.	Овоолгыг шүлтгүйжүүлэх явцад хүхрийн хүчилтэй уусмал нь хаягдал хүдэрт агуулагдсан маш бага агуулгатай хүдрийг уусмалын аргаар баяжуулснаар сульфаты өндөр агуулгатай ус овоолгын дор уллах үл хөрсний үст давхаргыг (грунтын ус) бохирдуулж байх магадлалтай.	Дунд. Хүхрийн агуулга, хүчлээр уусган баяжуулагдсан баялаг хүдрийн уусмал цөөрмийн районд алдагдаж, газрын хөрс рүү доош нэвчих, улмаар хөрсний үс (грунтын)-ны түвшинд хүрч холилдон (разбавленае) гүний усыг бохирдуулах геологи - гидрогеологи, гидродинамикийн урьдчилсан аятай нөхцөл бүрэлдэх магадлалтай.	2x2x3	12-Дунд
23.	Төслийн үйл ажиллагаанаас газрын доорх ус хүнд металаар бохирдох	Бага. Си, Е, Мо, Zn-ээр бохирдох бүрэн нөхцөлтэй.	1x1x2	2-Бага
24.	Шатах, тослох материал алдагдаж, усаар угаагдах замаар хөрсөнд нэвчих, газрын доорх бага гүний ус бохирдох	Бага. Анхаарал болгоомжгүй, гэнэтийн ослоос тээврийн хэрэгслийн шатах тослох материал алдагдаж болзошгүй.	2x1x2	4-Бага
<b>Ургамлан нөмрөг</b>				
25.	Уусгалтын үйл ажиллагаанаас хүхрийн хүчлийн сулруулсан уусмал алдагдах, ууршиж ургамлан нөмрөгт нөлөөлөх	Бага. Хүхрийн хүчлийн сул концентрацитай уусмалын ууршилтаас ургамлан нөмрөгт нөлөөлөхгүй байгааг талбай орчим зулзган хусан ой байгалийн жамаараа үүсэн хөгжиж байгаагаар баталгаажив байна.	1x1x2	2-Бага
26.	Уусган хандлах-электролизийн үе шатанд ургамлан нөмрөгт нөлөөлөх	Бага. “Эрдмин” үйлдвэр нь “Эрдэнэт” УБҮ-н талбайд байрлах ба уусган хандлах-электролизийн барилга байгууламжууд нь бодисын алдагдлаас сэргийлсэн бетонон суурьтай баригдсан тул талбай орчмын ургамлан нөмрөг нөлөө багатай.	1x2x2	4-Бага
27.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр ургамлан нөмрөг талхлагдах	Бага. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр орчны ургамлан нөмрөг талхлагдах, ажиллагсад зориулалтын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт багасах, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж /хог ургамал ихсэх/ зэрэг сөрөг нөлөөлүүд үүсэж болзошгүй.	3x1x2	6-Бага
<b>Амьтны аймаг</b>				
28.	Хөрс, ургамлан нөмрөг, усанд төслийн үйл ажиллагаанаас бохирдол үүсвэл тухайн ургамал, хөрс уснаас хоол тэжээлээ олж иддэг амьтдын зүйлд дам байдлаар сөргөөр нөлөөлж амьтны зүйл хордож, үхэж үрэгдэж болзошгүй.	Бага. Төслийн талбайд амьтад үзэгдэх боломжтой хэдий ч хүн амын суурьшилт, замын хөдөлгөөн, үйлдвэрийн хашаа зэргээс амьтны төрөл зүйлийн байршил өөрчлөгдсөн тул цаашид тэдгээрт үзүүлэх нөлөөлөл багатай.	1x1x2	2-Бага

Үнэлгээ: <6 -Нөлөөллийн түвшин бага анхаарал татахуйц биш

6-18 -Нөлөөллийн түвшин дунд, урьдчилан сэргийлж нөлөөллийг бууруулах боломжтой

>18 -Нөлөөллийн түвшин өндөр

“Эрдмин-Катодын зэс боловсруулах” үйлдвэрийн үйл ажиллагааны гол болзошгүй нөлөөллийн агаарын бохирдол, тоосжилт, дуу чимээ, гүний болон гадаргын усны бохирдлын эрчим нийт үнэлгээ 17 үзүүлэлтээс дунджаар 2-12 байгаа нь нөлөөллийн түвшин багаас-дунд зэрэг, байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлж, нөлөөллийг бууруулж зохицуулах боломжтойг харуулж байна.

Эх сурвалж: “Грийн Ассесмент” ХХК-ийн гүйцэтгэсэн “Эрдмин” ХХК-ийн “Балансын бус хүдрийн овоолгоос катодын зэс боловсруулах үйлдвэрийн төсөл”-ийн БОННУ-ийн нэмэлт тодотголын тайлан -2022он. Хуудас-120



## **ДӨРӨВ. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалт:

2023 оны БОМТ-г БОАЖЯ-нд хугацаанд нь танилцуулан хянуулж батлуулаад, үйлдвэрийн нийт инженер техникийн ажилтнуудад танилцуулж холбогдох хүмүүсийг үүрэгжүүлснээр төлөвлөгөө хэрэгжиж эхлэнэ.

Энгийн болон аюултай хог хаягдлыг устгах, шилжүүлэх гэрээг холбогдох байгууллагуудтай хийх.

Тухайн онд ашиглах химийн бодис болон ус, цахилгаан, дулаан зөвшөөрлүүдийг сунгуулах.

### Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:

Өмнөх жилүүдэд тарьсан моддыг арчлан ургуулах, хамгаалалтын хашааг засах.

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн цэгт хамгаалалтын хашаа барих, мод торих арчлан ургуулах.

Баян-Өндөр уулын эрд энгэрийн бэлээс урсан гардаг Хүрэнбулгын рашааны эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх, хамгаалалтын хашааг нь сэргээх ажлыг өмнөх жилүүдийн адил хариуцан гүйцэтгэх юм.

### Сөрөг нөлөөллийг бууруулах:

Төлсийн хэрэгжилтийн хугацаанд болон дараа нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдлуудыг урьдчилан тооцоолж түүнээс сэргийлэн ажиллах нь үндсэн зорилго юм.

Агаарын чанарыг доройтуулахаас сэргийлэхийн тулд тоосжилт үүсгэхгүй, үүссэн тохиолдолд бууруулах арга хэмжээг шуурхай авч ажиллах, хяналтыг тогтмол тавих. Автомашины замын тоосжилтоос сэргийлж шинээр хөрс эвдэн зам гаргахгүй байх тал дээр анхаарах.

Гадаргын болон газрын доорх усны нөөц, санг хамгаалах чиглэлд онцгой анхаарч уусмал хуримтлуулах цөөрөм, суваг шуудуу зэргийг 24 цагын турш тогтмол хянаж ажиллах. Үйлдвэрлэлийн хэрэгцээний ус ашиглалтыг холбогдох журмын дагуу зөвшөөрөл авч гэрээ байгуулж ажиллах, усны балансад хяналт тавих.

### Нөхөн сэргээлт:

Үйлдвэрийн хаалтад бэлтгэн байгаль орчныг нөхөн сэргээх сангын мөнгөн хуримтлалыг санхүүгийн хэсэг хариуцан гүйцэтгэнэ.

Үйлдвэрийн овоолгын талбайруу түрж ургасан зулзган моддыг шилжүүлжэн суулгах ажил хийгдэнэ.

### Орчны хяналт шинжилгээний ажил:

Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулан гүний усны хяналтын 7 цооногоос сар бүр дээж авч хяналт тавих, хөрсний 5 цэгээс жилд 2 удаа, агаарын бохирдлыг хянах 4 цэгээс жилд 4 удаа шинжилж хянах.

Электролизын банн орчимд агаар дахь хүхрийн хүчлийн ууршилтыг стандарчилал



хэмжилзүйн лабораторитой гэрээ байгуулан сар тутам шинжлүүлж хянах.

Хог хаягдлын менежмент:

Аймгийн хот тохижуулах газартай гэрээгээ сунган, орон нутгын хогны төвлөрсөн цэгт ахуйн хог хаягдлаа хаях.

Дахин боловсруулах ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэх.

Химийн бодисын хуримтлагдсан сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ хийж устгалд оруулах.

Автотээврийн хэрэгслүүдийн хэрэглээнээс үүдэлтэй хуримтлагдсан тосолгооны бодис, хөргөлтийн шингэнийг тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ хийж дахин боловсруулалтад өгөх.

Химийн хортой болон аюултай бодисын менежментийн талаар:

Химийн хортой аюултай бодисыг хадгалах, ашиглах, тээвэрлэх, устгах журмын дагуу үйлдвэрлэлд хэрэглэх химийн бодисуудын хадгалалт, ашиглалт, бүртгэл зэрэгт химич инженер, ХАБЭА хариуцсан ажилтан, металлурги инженер, химийн бодисын агуулах нярав нар тогтмол хяналт тавьж ажиллах.

Ашиглагдахгүй болсон нэр шошго тодорхой бус химийн бодисын хаягдлыг горимын дагуу үргэлжлүүлэн хадгалах, устгалд оруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан устгуулах.

Хүхрийн хүчлийн гаалийн түр агуулахыг холбогдох дүрэм журмын шаардлагыг хангуулан үргэлжлүүлэн өндөр хяналттайгаар ашиглах.



**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД ХИЙГДЭХ АЖЛУУД**

**ТАВ. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян. ₮/	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян. ₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг						
	1	2	3	4	5	6	7	8	9						
1.	Агаарын чанар Тээврийн хэрэгслүүдийн элэгдлийн улмаас ялгаруулах утааны хэмжээ стандартаас хэтэрч агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Компанийн тээврийн хэрэгслүүдийн яндангаас гарах утааг хянах, стандартаас хэтэрсэн хэтэрсэн тохиолдолд бууруулах арга хэмжээг авах, утаа шүүгчээр тоноглох	Компанийн тээврийн хэрэгслүүд	ш	50	16	800	1-р улиралд	Агаарын тухай хууль Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага MNS6342:2012						
2.	Агаарын чанар Уусган хандлалт, электролизийн үйл ажиллагаанаас химийн бодисын ууршилт үүсэх	Агаарын чанарын шинжилгээ судалгааг тогтмол хийлгэж үр дүнг агаарын чанарын стандарттай харьцуулан судалж сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах	Үйлдвэрийн эзэмшил газар	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан						Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, Техникийн ерөнхий шаардлага MNS6063:2010					
3.	Газрын доорх Уусгалт, уусган хандлалт, электролизийн процессийн явцад хүхрийн хүчлийн сулруулсан уусмал алдагдах гадаргын	Уусмал алдах болзошгүй эрсдэлээс сэргийлж тогтмол хянаж ажиллах	Уусган хандлалт электролизийн цехүүд							Усан орчны чанарын үзүүлэлт MNS 4586:1998					



		усанд нөлөөлөх								
4.		Хэрэглээний ус авч ашигласнаас үүдэн усны нөөц хомсдоход нөлөө үзүүлэх, бохир усаар гадаргын ус бохирдох	Үйлдвэрлэл болон ахуйн хэрэгцээний усны зөвшөөрөл авах, “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-тай бохир ус татан зайлуулах гэрээ хийх, усны хэрэглээний блансад тогтмол хяналт тавих	Катодын зэс боловсруулах үйлдвэр, Зэс утасны үйлдвэр	Шоо метр	0	38000	0	Үйл ажиллагааны явцад тогтмол.	
5.	Хөрс, ургамал	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас газрын гадаргад эвдрэл хөрсөн бүрхэвч элэгдэх ургамлан нөмрөг талхлагдах	Үйлдвэрийн орчинд мод тарих тарьсан моднуудыг арчлах	Үйлдвэрийн эзэмшлийн талбай	Га	0	1	0	Хавар намар	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
6.		Үйлдвэрлэлийн технологид хэрэглэгдэх химийн бодис хөрсөн бүрхэвчинд алдагдах, хүнд металлаар бохирдуулах	Итгэмжлэгдсэн лаборатороор хөрсний мониторингийн цэгүүдэд хүнд металлын шинжилгээ хийлгэх.	Үйлдвэрийн эзэмшлийн талбай	2 цэг	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан			6-р сар	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт MNS5914:2008
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал - 800,000₮</b>										



**ЗУРГАА. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө**

№	Нөхөн сэргээлтийн зорилт		Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян. ₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1		2	3	4	5	6	7	8
7.	Төслийн хаалтын хуримтлалын сан бүрдүүлэх	Үйлдвэрийг хаах, байгаль орчныг нөхөн сэргээх зардлын санг үргэлжлүүлэн хуримтлуулах	Үйлдвэрийн хаалтын үед шаардагдах нөхөн сэргээлтийн зардлын хуримтлалыг үйлдвэрийн захирлуудын зөвлөлийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээлтийн дансанд шилжүүлэн байршуулах	Төгрөг	1	5000	5000	Жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31-р зүйл
<b>Нөхөн сэргээлтийн арга хэмжээний зардал - 5 000 000₮</b>									

**ДОЛОО. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян. ₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
8.	Бүс нутгийн цөлжилтө өс сэргийлэх	2023 оны хавар, намрын бүх нийтээрээ мод тарих өдрүүдээр орон нутгаас зааж өгсөн газарт 1000 ширхэг бут сөөг тарьж арчлан ургуулж хамгаалах	7га	1000ш мод	2	2000	3-10-р сар	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ” Монгол улсын ЗГ-ын 2021.11.17-ы 350-р тогтоол
9.		1000 ш мод тарихад зориулж хамгаалалтын хашаа барих		1200м торон хашаа	Үйлдвэрлэлийн зардлаар			
10.	Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Өмнө жилүүдэд тарьсан моднуудын ургалт, хамгаалалтанд анхаарах, шаардлагатай тохиолдолд нөхөн тарилт	1.5га	1410ш мод 6 удаа услах	0,5	300	Жилийн турш	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журам (Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16- ны өдрийн 374 дүгээр тогтоол)
11.	Эрдэнэтийн овооны ард тарьсан моднуудын арчлалт хамгаалалт	0,8га	800ш мод 2 удаа	100	200			
12.	Булаг шандны эхийг хамгаалах.	Баян-Өндөр сумын Хүрэнбулаг багийн нутаг дэвсгэр дэх Хүрэнбулгийн рашааны хамгаалалтын хашааг будаж тордох	0,06га	1 удаа	64	64	6-р сард	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
13.	Эзэнгүй дүүргийн хог хаягдлыг цэвэрлэх	Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд зохион байгуулах эзэнгүй дүүргийн хог хаягдлын цэвэрлэгээний ажилд БОАЖГ-ын зааж өгсөн талбайг цэвэрлэж нэгдсэн хогийн цэг рүү зайлуулах.	Орхон аймгийн эзэмшлийн бүс	-	-	215	4-6-р сард	
<b>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал - 2 779 000₮</b>								



**НАЙМ. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө**

№	Нөлөөлөлд өртөх	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян.₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
14.	Үйлдвэрийн хүдрийн овоолгийн талбайруу түрж ургасан зулзган моддыг шилжүүлэн суулгах	Мод шилжүүлэн суулгах	Ширхэг	20	4,3	86	5-р сард	
<b>Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний - 86 000₮</b>								

**ЕС. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян.₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	Археологийн дурсгал	Үйлдвэрийн бүсэд түүх дурсгалын эд өлгийн зүйлс байхгүй	-	-	-	-	-	-
	Палеонтологийн дурсгал		-	-	-	-	-	-
<b>Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний зардал - 0₮</b>								

**АРАВ. Осол, (химийн бодисын) эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян. ₮/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
15.	Задгай талбайд болон агуулахад хадгалагдаж буй шингэн хуурай нунтаг химийн бодисууд болон уур, тоос нь салхиар дамжин агаарт дэгдэх	Химийн бодисын сав баглаа боодлыг сайтар шалгаж химийн хортой аюултай бодис хадгалах журмыг мөрдлөг болгон ажиллах	Уусган хандлалт электролизын цех, химийн бодисын агуулахын орчим Уусгалтын хэсэг	-	Хариуцан ажиллаж буй үйлдвэрийн ИТА-уудын ажил үүргийн хуваарьт хяналт шалгалт, хариуцлага, зэрэг нь багтдаг тул тусдаа зардал тооцогдохгүй		Тогтмол	Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгалд оруулах журам БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 2009 оны 28/40/29-р хамтарсан тушаал  Гамшгаас хамгаалах тухай хууль  Усан орчны чанарын үзүүлэлт MNS4586:1998 Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага MNS 3342:1982
16.	Химийн бүтээгдэхүүн, түлш шатахуун асгарч алдагдан орчны агаар, хөрс бохирдох Хүхрийн хүчлийн баян, ядуу уусмалын цөөрмүүд, уусмал дамжих суваг шуудуу гэмтэж HDPE доторлогоо гэмтэж хүхрийн хүчлийн уусмал хөрс грунт рүү нэвчин, гүний усыг бохирдуулах	Хамт хадгалж болохгүй химийн бодисуудын журмыг мөрдөж, хяналт тавьж ажиллах. Гамшиг ослоос хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх. Цөөрмүүдийн хяналтын цооногуудаас шинжилгээ авч тогтмол хянах, HDPE доторлогоонд тогтмол үзлэг шалгалт хийж байх		-				
<b>Осол, эрсдэлийн менежментийн зардал - 0₮</b>								



АРВАН НЭГ . Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /мян. ₮/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян. ₮ /	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг	
	1	2	3	4	5	6	7	8	9	
17.	Ахуйн хог хаягдал	Үйлдвэрийн ахуйн хог хаягдлыг аймгийн төвлөрсөн цэгт зөөвөрлөн хаях	Эрдмин үйлвэрийн эзэмшил талбай	м <sup>3</sup>	11,5	36	414	Хог түр хадгалах цэгт хуримтлагдсан тохиолдолд	Хог хаягдлын тухай хууль 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр	
18.		Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулалтад шилжүүлэх		м <sup>3</sup>	16,6	3	49,8			
19.	Үйлдвэрлэлийн хог хаягдал	Үйлдвэрийн хаягдал болох шлам хаях цэгийг засварлах (тунгаах хэсэгтэй болгох) ажлыг үргэлжлүүлэх		м <sup>3</sup>	Үйлдвэрлэлийн зардал	400	-	5-р сар	Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгалд оруулах журам БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайд, ОБЕГ-ын даргын 2009 оны 28/40/29-р хамтарсан тушаал Аюултай хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт	
20.		Химийн лабораторын ашиглагдахгүй болсон бодисуудыг холбогдох журмын дагуу хадгалах, тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар устгуулах		кг	50	38	1900	1 удаа		
21.	Аюултай хог хаягдал	Эмнэлгийн хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар зориулалтын цэгт устгуулах		Эрдмин үйлвэрийн эзэмшил талбай	Кг	5	10	50		2 удаа
22.		Автомашинд хэрэглэсэн тосолгооны бодисыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй ААН –д шилжүүлэх		литр	0.15	1200	180	1 удаа		Аюултай хог хаягдлын жагсаалт Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 2 дүгээр



23.	Химийн бодисын хуримтлагдсан хуванцар савнууд устгалд өгөх	кг	300	3,2	960	1 удаа	хавсралт
<b>Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал – 3 553 800₮</b>							

**АРВАН ХОЁР. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа, давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, /мян. ₮/	Нийт зардал, /мян. ₮/	Тайлбар	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
24.	Агаарын орчны хяналт: SO <sub>2</sub> , NO <sub>2</sub>	- Үйлдвэрийн харуулын байр орчим - Гүний усны хяналтын 5-р цооног орчим - Зэс хайлах цех дотор - Цувих цех дотор	Жилдээ 4 удаа	8	70,5	564	Эрдмин үйлдвэрийн орчим, эзэмшил талбай, үйлдвэрийн барилга байгууламж дотор	- Шинжилгээний аргын стандарт: MNS ISO 11923:2001 MNS 6271:2011 MNS 17.2.5 12:88 MNS 17.2.5 11:88 MNS 3310:1991 MNS 3307:1991
25.	Хөрсний орчны хяналт. Агрохимийн үзүүлэлтүүд /рН, SO <sub>4</sub> , Р, ялзмаг, /	- Үйлдвэрийн харуулын байрны орчим - Гүний усны хяналтын 2-р цооногийн орчим - Электролизын цехийн орчим - Үйлдвэрийн харуулын байр орчим - Цувих цех орчим	6 сар тутамд 1 удаа	10	62	620		- Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 - Агаарын чанар Техникийн ерөнхий





26.	Гүний усны орчны хяналт. /рН, SO <sub>4</sub> , Cu /	Гүний усны хяналтын 7ш цооног	Сард 1 удаа	84	16	1344	шаардлага MNS 4585:2016 -Байгаль хамгаалал. Шинжилгээний дээж авахад тавтгдах ерөнхий шаардлага MNS 12.060-1991 -Ажлын байрны агаар дахь хорт бодисыг индикаторын гуурсаар тодорхойлоход тавих ерөнхий шаардлага. MNS 5028:2001
27.	Агаар дахь хүхрийн хүчлийн ууршилтын хэмжээ	EW цех дотор, электролизын банны орчимд	Сард 1 удаа	12	13,5	162	
<b>Орчны хяналт шинжилгээний зардал - 2 690 000₮</b>							

**АРВАН ГУРАВ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцоолсон төсөв / мян. Төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
28.	Нийт инженер техникийн ажилтнуудад 2022 оны БОМТ-ийг танилцуулах, хэрэгжүүлэх шуурхай удирдлагаар хангах.	5000	Жилийн турш			БО-ы асуудал хариуцсан ажилтан	-
<b>Удирдлага зохион байгуулалтын зардал - 5 000 000₮</b>							



**АРВАН ДӨРӨВ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан / ажилтан	Зохион байгуулах газар
29	Орхон аймгийн Баянцагаан багийн иргэд	Бэхжүүлсэн (бичиг баримт, илтгэл тавих) хэлбэрээр болон газар дээр нь танилцуулах	2023 онд болон төсөл хэрэгжих хугацаанд гарсан Байгаль орчны тохирол, үл тохирол хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэл	8-р сар	49,8	БО-ы асуудал хариуцсан ажилтан	Эрдмин үйлвэрийн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр
30	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хянах, үнэлгээ өгөх ажлын хэсгийн гишүүд			10-р сард	49,8	Ерөнхий захирал БО-ы асуудал хариуцсан ажилтан	
<b>Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зардал - 99 600₮</b>							
<b>БОМТ-г хэрэгжүүлэх нийт төсөв - 20 008 400₮</b>							